



ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 04 сарын 07 -ны өдөр

Дугаар А/91

Эрдэнэт

“Эрүүл мэндийг дэмжих төв” байгуулах
ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 12.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн харьяа “ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ ТӨВ” байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр хавсралтаар, туршлага судлах аяны удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “Эрүүл мэндийг дэмжих төв” байгуулах төслийг боловсруулан батлуулж, 2020 оны 10 дугаар сарын 01-ний дотор Нийгмийн бодлогын хэлтэст хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд үүрэг болгосугай.

3. “Эрүүл мэндийг дэмжих төв” байгуулахтай холбогдуулан лавлагаа шатлалын эмнэлгүүдэд туршлага судлах аяныг зохион байгуулж, шаардлагатай санхүүгийн зардлыг тооцож олгохыг Салбарын санхүү бүртгэл мэдээлэл, нягтлан бодохын бүртгэлийн ажилтан /Н.Чулуун-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын мэргэжилтэн /Г.Энхжаргал/-д даалгасугай.

ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.СҮХЭЭ

Эрүүл мэндийн газрын 2020 оны 09 дүгээр сарын 07-ний
өдрийн 14 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



“ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ ТӨВ” байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн:

Ажлын хэсгийн ахлагч:

- ЭМГ-ын Яаралтай, гамшгийн үеийн тусламж үйлчилгээ хариуцсан
мэргэжилтэн Б.Уртнасан
- БОЭТ-н эмчилгээ эрхэлсэн орлогч захирал Б.Одонтунгалаг

Нарийн бичиг:

- БОЭТ-н гадаад харилцаа эрдэм шинжилгээ сургалт хариуцсан ажилтан
М.Ундрахсайхан

Гишүүд:

- ЭМГ-ын хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан
мэргэжилтэн Г.Энхжаргал
- ЭМГ-ын сувилахуй, хөнгөвчлөх тусламж үйлчилгээ хариуцсан
мэргэжилтэн А.Баярхүү
- ЭМГ-ын Эрүүл мэндийн эдийн засаг, төсвийн төлөвлөлт,
зохицуулалт хариуцсан мэргэжилтэн Д.Отгондэлгэр
- БОЭТ-н санхүү эрхэлсэн дэд захирал Э.Баасанжаргал
- БОЭТ-н хүний нөөцийн албаны дарга А.Отгон
- БОЭТ-н амбулаторийн тасгийн эрхлэгч Л.Тунгалагтамир
- БОЭТ-н лабораторийн тасгийн эрхлэгч Л.Баяржаргал
- БОЭТ-н мэдээллийн технологийн ажилтан Б.Нямхүү

Эрүүл мэндийн газрын 2020 оны 9 дүгээр сарын 9-ний
өдрийн 14 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



ТУРШЛАГА СУДЛАХ АЯНЫ УДИРДАМЖ

ЗОРИЛГО: Лавлагаа шатлалын эмнэлгүүдийн эрүүл мэндийг дэмжих, урьдчилан сэргийлэх төвийн үйл ажиллагаатай танилцаж, орон нутагт Эрүүл мэндийг дэмжих төв байгуулах төслийг боловсруулан, Эрүүл мэндийн яам болон орон нутгийн удирдлагуудад танилцуулан дэмжлэг авах, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах

Туршлага судлах эрүүл мэндийн байгууллагууд: Улсын Нэгдүгээр төв эмнэлэг, Улсын Хоёрдугаар төв эмнэлэг, П.Н.Шастины нэрэмжит Улсын Гуравдугаар төв эмнэлэг

Туршлага судлах баг бүрэлдэхүүн: ЭМГ, БОЭТ-ийн дарга нар, Эрүүл мэндийг дэмжих төв байгуулах ажлын хэсгийн ахлагч, гишүүд нар

Туршлага судлах чиглэл:

1. Туршлага судлах байгууллагын үйл ажиллагаатай танилцах
2. Эрүүл мэндийг дэмжих төв байгуулах эрх зүйн баримт бичгийг судлаж танилцах
3. Эрүүл мэндийг дэмжих, урьдчилан сэргийлэх төвийн урсгал, зохион байгуулалтын зураглалыг гаргах
4. Эрүүл мэндийг дэмжих, урьдчилан сэргийлэх төвийг нээхэд шаардлагатай багаж тоног төхөөрөмжийн судалгааг гаргах, санхүүжилт, даатгалын үйлчилгээг судлах
5. Эрүүл мэндийг дэмжих, урьдчилан сэргийлэх төвийн мэдээллийн технологи харилцаа холбоог судлах
6. Эрүүл мэндийг дэмжих, урьдчилан сэргийлэх төвөөс үзүүлж буй тусламж үйлчилгээний төрлүүдийг судлах
7. Хүний нөөцийн бүрдүүлэлт, сургаж дадлагажуулах төлөвлөлт хийх

Туршлага судлах аяны хугацаа: Улсын Нэгдүгээр төв эмнэлэг, Хоёрдугаар төв эмнэлэгт 2020 оны 9 дүгээр сарын 10-ний өдөр, Н.Шастины нэрэмжит Улсын Гуравдугаар төв эмнэлэгт 2020 оны 9 дүгээр сарын 11-ны өдөр тус тус туршлага судлах

Туршлага судлах аяны үр дүн: Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн харьяа “Эрүүл мэндийн дэмжих төв”-ийг байгуулах төслийн баримт бичгийг боловсруулж, орон нутагт танилцуулах

Удирдамж боловсруулсан: ЯГҮТҮХМэргэжилтэн  Б.Уртнасан